

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Хүрлээ	Дугаар	L162
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ	Оршин суугаа сум	Ерөө
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дарь эхийн хурал, Гучингийн хийд	Сүм хийдийн дугаар	СЭЕР 037, СЭЕР 041
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Дарь эхийн хурал, Гучингийн жас

2007 оны 7-р сарын 21-ний өдөр. Судалгааны баг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн өндөр настан Хүрлээ гуйтай уулзаад байна.

Асуулт:- Та Дарь эхийн хийд, **Хорингийн хийд, Гучингийн** хурлын тухай ярьж өгөөч?

Хариулт:-Дарь эхийн хийдэд би барагтай л бол 5, 6 хэрийн настай юмуу даа тийм байх үедээ багаас хөөгдөж Дарь эхийн хийд дээр **Лхам** хурахад хашин хааны цагаан өвгөний хүүхдэд тоглож байсан.

Асуулт:-Хэдэн сарын үед цам гардаг байсан юм бэ?

Хариулт:-Зуны эхэн сарын шинийн 8-ны үед тэгж хурж байсан юм уу даа.

Асуулт:-Жилд нэг удаа гардаг байсан уу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Цамынхаа хувцас хэрэглэлийг өөрсдөө хийдэг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-**Тэгэлгүй яахав**, тэндээ бүр бэлэн тэр хүүхдүүдийн өмсдөг хувцас, баг, бүгдийг нь бэлэн энд. Зураач Наваан гуай, Даш дархан гуай гэж зураач Наваан гуайн ах нь Даш дархан гуай баг юмыг нь хийнэ. Ерөөсөө бүгдийг нь. Будаг **шудаг** хамаг юмнуудыг нь **Буургачингаас** л 5 өнгийн будаг авч эндээс л авч байгаа шүү дээ, тэрнээс улсаас бол ерөөсөө сохор зоосны юм гаргаагүй.

Асуулт:-Цамынхаа өмсгөлийг юугаар хийдэг байсан юм бэ? Торгоор уу?

Хариулт:-Цамын өмсгөлийг голдуу хоргой, магнаг ч билүү тийм юмнуудаар л хийнэ дээ.

Асуулт:-Толгойд өмсдөг баг байна шүү дээ, тэрнийг юугаар хийдэг байсан юм бол?

Хариулт:-Тэрнийг чинь **барималаар хийчихнэ**. Нүд, ам юутай хээтэй баримлаар хөнгөхөн. Хэвэнд цутгаад хийчихнэ.

Асуулт:-Багийг нь Наваан гуай хийдэг байсан юмуу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Наваан гуай болохоор Дарь эхийн хийдийн гол шүтээнүүдийг нь, ер нь бүх л бурхан тахилыг нь хийдэг хүн гэсэн тийм ээ?

Хариулт:-Тэгэлгүй **яахав**, уран барималч. Одоогоор юм бол уран барималч тийм хүн.

Асуулт:-Дарь эхийн хийд хэд орчим ламтай байсан юм бэ?

Хариулт:-Дарь эхийн хийддээ 60-аад лам хүрж байсан байх, 4 **жавзанд**.

Асуулт:-Нэг л дуганд хурал номоо хурчихдаг байсан **юмуу, Чойр**, Зурхай гээд тусдаа байсан юмуу?

Хариулт:-Тус тусдаа

Асуулт:-Хамба лам нь хэн гэдэг хүн байсан юм бэ?

Хариулт:-**Чойдогха** гэдэг хүн байсан юм.

Асуулт:-Монгол хүн үү, төвд үү?

Хариулт:-Монгол

Асуулт:-Дарь эхийн хийд Төвд, Энэтхэгийн **дацангуудтай** холбоотой байсан уу? Ламаа сургадаг, нааш нь цааш нь явуулдаг байсан уу?

Хариулт:-Энэтхэг мэдэхгүй, ер нь Богдоос л цагаан сарын битүүний орой багтаж 9 цагаан бэлэг гэж Дарь эхийн дуган дээр ирдэг. Богдын мэндтэй тийм дуган л даа. 9 цагаан бэлэг гэж Богдоос мэндчилгээ ирдэг. Тийм байсан. Тэгээд хариу юу явуулдаг, Дарь эхийн дуган дээрээс.

Асуулт:-**Гэсгүй** лам нь хэн гэдэг хүн байсан юм бэ?

Хариулт:-Доржпалам гэж хүн байсан.

Асуулт:-Та өөрөө шавилж сууж байсан уу?

Хариулт:-Үгүй ээ, би 5, 6 настай багаас хөөгдөөд л **яахав** Цагаан өвгөний хүүхдэд очиж тогло гээд л **нэг орон** тоо очдог.

Асуулт:-Цам, **Майдар** эргэх үеэр нутгийн ардууд бүгд цугладаг байсан уу?

Хариулт:-Цуглана, их цуглана.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Дарь эхийн хийдийн лам нар ямар уул хангайгаа тахидаг байсан юм бол?

Хариулт:-Энэ **Буургачингаа** тахина, цаад **Эрдэнэ хангайг** голдуу хүүхдүүдэд зориулж тахина. Энэ багийн ардууд Хөх чулуутыг голдуу тахиж байсан юм. Дарь эхийн дуганы чинь юунд дандаа цагаан идээгээр хангайгаа, Хөх чулуутыг шүүсээр тахина.

Асуулт:-Хэдий үед тахих үү?

Хариулт:-Голдуу зуны эхэн сард л бороо хур гуйж, тэнгэр хангайгаас. Зуны дэлгэр цагт л, тэр байдлаасаа л болно. Тэр зун хаашаа **байнав**, ямар янзын зуншлага ямар янзтай **байнав**, тэр байдлаасаа болж тахидаг.

Асуулт:-Анх хэдий үед үүсэлтэй, ямар хүн байгуулсан гэдэг түүхтэй юм бол?

Хариулт:-Тэрнийг мэдэхгүй.

Асуулт:-Сүүлд хэдэн оны үед устгагдсан, юу болсон бэ?

Хариулт:-1928 онд л **дуганын** бүх лам нарыг баривчлаад дуганыг чинь ногоон малгайтан гэдэг дотоодын хамгаалах газрын улсууд л энийг чинь шатаагаад тэгээд зүйл дуусгасан юм даа.

Асуулт:-Дарь эхийн ламын хурал аль чиглэлийнх байсан бэ? шарынх үү, улааных үү? Улааных чинь **жод, лүйжин** тавьдаг. Тэрний аль нь байсан бэ?

Хариулт:-Шарынх.

Асуулт:-Дарь эхийн хийдэд хутагт, хувилгаад том мяндагтай лам нар байсан үү?

Хариулт:-Голдуу л гэлэн, **гэцэл** тийм л улсууд байсан даа. Хамба, цорж тийм юм байгаагүй байхаа.

Асуулт:-Сүмийг хаагдсаны дараа бурхан шүтээнийг нь яасан юм бол?

Хариулт:-Байхгүй, эвдээд хаяхгүй юу.

Асуулт:-Хуучны засаг захиргааны хуваариар **Түшээт** хан аймгийн ямар хошуу гэх вэ?

Хариулт:-Зүүн сүм, Далан баг гэж байсан юм.

Асуулт:-Бүр хуучин, хувьсгалаас өмнөх хуваариар бол? Хувьсгалаас өмнө **Эрдэнэ вангийн** хошуу гэх үү, Баатар вангийн хошуу гэх үү?

Хариулт:-**Эрдэнэ вангийн** хошуу

Асуулт:-Та Ерөөгийн Хадны ламын сүмийн хурлын тухай юу мэдэх вэ?

Хариулт:-Хадны лам ганц лам л байсан юм, 4 суваргатай байл уу даа, 3 суваргатай байл уу, тэр ер нь хамаагүй ердийн хүн л дээ.

Асуулт:-Тусдаа дугантай байсан юмуу, зүгээр л хадны агуйд сууж байдаг хүн байсан юмуу?

Хариулт:-Энд хааяа ирж уншлага **хийчихээд** тэгээд Зүүнхараагаар ороод тэгээд Улаанбаатар явчихдаг.

Асуулт:-Хэдэн оны үе гэсэн үг вэ?

Хариулт:-Ардын хувьсгалаас өмнө шахуу байсан байх аа, хадны лам чинь.

Асуулт:-Тэр хүний нэр алдрыг хэн гэдэг байсан юм бол?

Хариулт:-Хадны ламыг чинь Дамбажанцан гэдэг хүн байл уу даа. Манай Бүдүүн Бямбаагийн ижийтэй сүүлд сууж байсан даа, **Наанай** гээд Найдан гэдэг өвгөн. Тэр **адуугий** нь маллаж байсан юм, Хадны ламын.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Сүүлд хэдэн онд нас барсан юм бэ?

Хариулт:-Тэгээд л урагшаа очоод л байхгүй.

Асуулт:-Бас баривчлагдсан уу?

Хариулт:-Бүгдийг гамин шоронд хийгээд, тэгээд цагаан ирж, төр засгийг тохинуулна гээд Богдыг чинь гаргасан шүү дээ. Тэгэхэд Хадны лам чинь богдтой цуг тэнд шоронд хоригдож байсан юм гэнэ лээ. **Жавзандамба** хутагтаа хятад, орос хоёрыг шаахайны мөргүй болгочихъё гэж. Яаж **болохов** гэж. Яаж шаахайны мөргүй **болгохов** гэсэн чинь ямар юм **байхав** уулыг нь шатаагаад, усыг нь урсгаад, усыг нь буцалгаад тэгээд шаахайны мөргүй болно. Тэгэхээр чинь өөрсдөө хаана байх гэв гэсэн аан нээрээ тийм шүү бас, тэрнийгээ бодохгүй бол болохгүй гэж. Хадны лам гэдэг хүн тийм хувилгаан хүн байсан юм. Ямар сайндаа Барон орж ирээд Богд хаана **байнав** гэхэд харагдуулахгүй байсан гэсэн шүү дээ, араараа **халхалчихаад**. Тийм **увидастай**, чадалтай лам байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Дамбажанцан гуай энэ нутгийн уугуул иргэн үү?

Хариулт:-Хотынх. Аягүй бол Төвд юуных ч байж магадгүй.

Асуулт:-Яагаад заавал ганцаараа хаданд очиж суугаад байдаг байсан юм бэ?

Хариулт:-Одоогоор юм бол зожиг гэж ярих уу даа.

Асуулт:-Агуйд суудаг байсан юмүү?

Хариулт:-Агуйд

Асуулт:-Сүүлд хэдэн онд нас барсан гэж үзэх вэ? Тэр хүнийг.

Хариулт:-Богд эд нартай цуг тэгээд л таалал төгссөн шүү дээ.

Асуулт:-Одоо үр хүүхэд, ач гуч нь энд бий юу?

Хариулт:-Байхгүй.

Асуулт:-Далангийн хурлын тухай юу мэдэх вэ?

Хариулт:-Хуст уул гэдэг газар байна уу, үгүй юу? Далангийн хурал гэж.

Асуулт:-Цагаан тохойн юуг ярьж байна уу?

Хариулт:-Хуст биш ээ. Улаан гэж тэр хойд талдаа өндөр уул байгаа, тэрний өвөрт байсан юм.

Асуулт:-Тэр хурлын тухай та юу мэдэх вэ?

Хариулт:-Бас нэг 30, 40-өөд ламтай, тэд нар тэндээ л хурлаа хурчихна, наашаа Дарь эхийн дуган эд нар дээр ирж яахгүй.

Асуулт:-Томоохон лам нараас нь нэр усыг нь мэдэх үү?

Хариулт:-Том лам одоо энэ Дарь эхийн **дуганын** том лам **Чойдогха** тэрнийг бас хариуцаж. Тэрнээс нэг их том лам байхгүй.

Асуулт:-Далангийн хурлыг ямар хүн үүсгэн байгуулж дуган барив?

Хариулт:-Дарь эхийн дуганаас л хүн очиж тэнд буй болгож зурхайч, барималч тэд нар нь тэнд юмыг нь бүтээгээд тэгээд л буй болгосон.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-**Гучингийн** хурлын тухай юу мэдэх вэ?

Хариулт:-**Гучингийн** хурал жижигхэн 10-аад лам шавилан суудаг.

Асуулт:-Газар нь хаана ямар нэртэй газар байдаг юм бэ? одоо олж очвол?

Хариулт:-Одоо 80 милийн тал гэж яриад байгаа тэр хавьд л байсан юм уу даа.

Асуулт:-Чулуу, суурь юм үлдэгдэл байдаг юм болов уу?

Хариулт:-Суурь байхгүй байхаа. Хиргисүүр чухам байна уу, үгүй юу мэдэхгүй?

Асуулт:-Бас Дарь эх ламын хийдээс гаралтай юу?

Хариулт:-Үгүй. Тэр чинь хойноосоо буй болгосон байх, Алтанбулаг, Хиагт эд нараас. Тэндээс л гаралтай үүсэлтэй юм даг.

Асуулт:-Тэнд том сүм энд байсан гэсэн үг үү?

Хариулт:-Хаана?

Асуулт:-Алтанбулаг эд нарт чинь.

Хариулт:-**Яахав** дээ, жижиг дуган байхгүй юу.

Асуулт:-Тэндээс гаралтай гэж үү?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Яагаад **Хорингийн, Гучингийн, Далангийн** гэж нэрлэсэн юм бол?

Хариулт:-Тэр лам нарынхаа тоогоор л яаж байгаа.

Асуулт:-Тийшээгээ бага, ийшлэх тусам тоо нь ихээд байсан юм байна?

Хариулт:-Тийм.